## УСНЫ ГАЗРЫН УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.**Салбарын удирдлагын манлайллыг хангах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахад хууль, эрх зүйн зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, салбарын яам, сайдаас өгсөн ажлын чиглэлийг хэрэгжүүлэх | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 2024 онд 86 хувьтай хэрэгжүүлсэн | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжоор хариуцуулсан болон эрх бүхий албан тушаалтаас иргүүлсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж хариуг хүргүүлсэн байна. | "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого /20 арга хэмжээ/, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /8 арга хэмжээ/, Шинэ сэргэлтийн бодлого /2 арга хэмжээ/, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /4 арга хэмжээ/ зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан 21 чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 2024 оны гүйцэтгэлийн нэмэлт тайланг 2025.04.25-нд БОУАӨЯ-ны БНБХГ-т цахимаар хүргүүлсэн. Мөн Хууль тогтоомж, тогтоол шийдвэртэй холбоотой 17 чиг үүргийн хэрэгжүүлж ажиллан тайланг 2025 оны I улирлын байдлаар гаргаж 2025.04.07-нд БОУАӨЯ-ны БНБХГ-т цахимаар хүргүүлсэн. | 01-06 | 85 |
| 2 | Арга хэмжээ 1.2.Авлигын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь | 81.0 | "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-г боловсруулж, эхний хагас жилийн байдлаар 80-аас доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан цахимаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлангийн хугацаа болоогүй. Мөн "Шударга байдлын үнэлгээ-2024" судалгааны тайлантай танилцан "Байгууллагын шударга байдлын үнэлгээг сайжруулах" 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар байтуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээнүүдийн явцын зорилтод түвшинд хамаарах гүйцэтгэлийг гаргаж дүгнэхэд 84.2 хувийн гүйцэтгэлтэй байна. | 05-06 | 100 |
| **Зорилт 2:** Олон Улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хилийн усыг ашиглах, хамгаалах хэлэлцээрийг хэрэгжүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээ 2.1.Усны нөөцийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах. | Зөвлөлийн хуралдааны тоо | 2 | Усны нөөцийн зөвлөлийн хуралдааны 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна. | Усны нөөцийн зөвлөлийн 2025 оны 4-р хуралдаан БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Усны нөөцийн зөвлөлийн даргын 2025 оны 4-р сарын 14-ний өдөр баталсан хурлын төлөвлөгөөний дагуу ХББОСЯ-ны хурлын танхимд 2025 оны 04 дүгээр сарын 18-нд зохион байгуулагдаж Усны нөөцийн зөвлөлийн үйл ажиллагаа болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлуудыг, "Хилийн усны хэлэлцээр"-ийн талаар, "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн хүрээнд хийгдэх судалгааны ажлуудын ажлын даалгаврыг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцсэн. 5 дугаар хуралдааныг ЦУОШГ-ын хурлын танхимд 2025 оны 05 дугаар сарын 20-нд зохион байгуулж 7 сав газрын уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулах төлөвлөгөөг болон усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэлэлцсэн. Зарцуулсан төсөв 9,476,000. Усны нөөцийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ус ашиглалтын хэлтсийн дарга Х.Мягмаржав ажиллаж мэдээллийг өгсөн | 01-05 | 100 |
| 4 | Арга хэмжээ 2.2.Усны нөөцийг бохирдож хомстохоос хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, олон улсын хамтын ажиллагаа, олон улсын гэрээ конвенц, хилийн усыг хамгаалах, ашиглах Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хилийн усны ажлын хэсэг, шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулах | Хамтарсан шинжээчдийн багийн протокол Бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Бүрэн эрхт төлөөлөгчдийн хэлэлцээрийг зохион байгуулж, протокол-1 үйлдсэн байна. | Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Хилийн усны хамтарсан комиссын Есдүгээр хуралдааныг 2025 оны 03 дугаар сарын 12-13 -ны өдрүүдэд зохион БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулж, Монгол Улсын талаас БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулгаар ахлуулсан 10 төлөөлөгч оролцож ажилласан. Нийт зарцуулсан төсөв 58.760.520 төгрөг. Тус хуралдаанд Усны газрын дарга З.Батбаяр, Удирдлага санхүүгийн хэлтсийн дарга Д.Сайханжаргал нар ажлын хэсэгт орж ажиллан мэдээллийг өгсөн. | 03-06 | 100 |
| **Зорилт 3:** Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, хууль эрхзүйн орчныг бүрдүүлж, усны нөөцийн нэгдсэн менежментийн зарчмыг хэрэгжүүлж, усны төлбөр үнэ тарифын уялдаа холбоог сайжруулах | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ 3.1.Усны газрын даргын А/169 дугаар тогтоолоор байгуулагдсан "Усны экологи, эдийн засгийн үнэлгээ болон үнэ, тарифыг өөрчлөн тогтоох чиглэлээр судалгаа, тооцоолол хийх ажлын хэсэг"-ээс усны үнэ тарифын талаарх судалгаа, саналыг сайдад хүргүүлэх. | Хүргүүлсэн санал-1 | Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол | "Усны экологи, эдийн засгийн үнэлгээ болон үнэ, тарифыг өөрчлөн тогтоох чиглэлээр судалгаа, тооцоолол хийх ажлын хэсэг"-ийн хуралдааныг 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна | Усны нөөцийн үнэ тарифыг тогтоосон 2 хууль, Засгийн газрын 4 тогтоол, Сайдын 1 тушаал батлагдсан.<br>2020 оноос хойш Засгийн газрын 2 тогтоолд нэмэлт өөрчлөлт орсон боловч усны суурь үнэ тарифт онцын ач холбогдолтой нөлөө үзүүлээгүй байна.<br>2024 онд агентлагийн даргын тушаалаар усны экологи эдийн засгийн үнэлгээ болон усны үнэ, тарифыг өөрчлөн тогтоох чиглэлээр судалгаа, тооцоолол хийх ажлын хэсгийг байгуулан 2 удаагийн хуралдааныг зохион байгуулан ажилласан байна. Миний бие тус ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. | 01-06 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ 3.2.Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр"-ийг өөрчлөх саналыг боловсруулж хүргүүлэх | Хүргүүлсэн санал-1 | Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоол | "Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр"-ийг өөрчлөх чиглэлээр судалгаа, тооцоолол хийх ажлын хэсэг"-ийн хуралдааныг 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна | Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Усны экологи,эдийн засгийн суурь үнэлгээг" баталсан боловч өөрчлөлт орж байгаагүй, 2 дугаар хавсралтаар "Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр"-ийг баталж 2013 онд нэмэлт өөрчлөлт оруулсан боловч дахин өөрчлөөгүй. "Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр"-ийг өөрчлөх чиглэлээр судалгаа, тооцоолол хийх ажлын хэсэг"-ийг шинэчлэн байгуулах шаардлагагүйгээр агентлагийн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/169 тушаалаар байгуулагдсан "Усны экологи, эдийн засгийн үнэлгээ болон үнэ, тарифыг өөрчлөн тогтоох чиглэлээр судалгаа, тооцоолол хийх ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүн хамтад нь шийдвэрлэх чиглэл өгсөн. Үүнтэй холбоотойгоор тус ажлын хэсгийн хуралдаанаар 2 удаа хэлэлцэж холбогдох судалгааг хийж байна. | 01-06 | 50 |
| **Зорилт 4:** Агентлагийн хэвийн үйл ажиллагааг хангаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг түгээн дэлгэрүүлэх, олон нийттэй харилцах | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 4.1.Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах | -"Цэнхэр алт" үндэсний чуулган зохион байгуулах.<br>- Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил зохион байгуулах | 2024 онд "Цэнхэр тууз" аяныг зохион байгуулсан | Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан сарын аян зохион байгуулах | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтран усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, салбарын бодлого, хууль эрх зүйг шинэчлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Цэнхэр алт" үндэсний хоёрдугаар чуулганыг Төрийн ордонд зохион байгуулав. Чуулганы өмнөх үйл ажиллагаануud<br>1.Оюутны эрдэм шинжилгээний бага хурал<br>2."Ус-Хөгжлийн түлхүүр" сэдвээр зохиогдож, шилдэг 10 илтгэлийг шалгаруулав.<br>Ахлах ангийн сурагчдын илтгэлийн уралдаан "Өөрчлөлтийг хурдасгая" сэдвээр 58 оролцогчоос 3 шилдгийг тодруулсан.<br>Үндэсний чуулганд нийт 13 улсын Элчин сайд, төрийн болон ТББ, судлаачид, нийт 927 төлөөлөгч оролцож усны салбарын тулгамдсан асуудлуудаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн.<br>Чуулганаас нийт 4 чиглэл, 19 заалт бүхий зөвлөмжийг гаргасан.<br>Чуулганыг олон нийтийн мэдээлэлд өргөн хүрээтэй хүрсэн (шууд дамжуулалт, нийтлэл, шторкууд) хүргэж 40,000 гаруй үзэгч, олон нийтэд хүрсэн байна. Нийт зарцуулсан төсөв 285.065.000 төгрөг | 03-06 | 100 |
| **Зорилт 5:** Үйл ажиллагааны тасралтгүй, хүртээмжтэй хурдан шуурхай байдлыг хангаж, үйл ажиллагааг цахимжуулах. | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэх ажлын үр дүнг сайжруулах. | Ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн гүйцэтгэлийн хувь | 100 | .Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн ажлын гүйцэтгэл 90 хувиас дээш байна | 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 59, явуулсан бичиг 33, тодорхойлолт авах тухай 1 өргөдөл хүлээн авч цахим архив үүсгэсэн. Үүнээс ирсэн 57 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 албан бичиг хариу өгөхөөр судлагдаж байгаа буюу нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлт 96.6 хувьтай байна. Нийт албан бичгийн хугацаатай 10 албан бичгийг шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 9 хоногт шийдвэрлэсэн байна. | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Арга хэмжээ 5.2.Нэгжийн албан хаагчдад мэдээллийг шуурхай хүргэх, бусад нэгжтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллах, ажлын уялдааг зохион байгуулах, хяналт тавих | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Байгууллагын үйл ажиллагааны чанарын үзүүлэлт дээшилсэн байна. | Нэгжийн албан хаагчдыг мэдээллээр хангах хүрээнд Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийг ERP систем болон байгууллагын дотоод цахим шуудангаар 5 удаа мэдээлэлж, Агентлагийн дарга болон хэлтсийн даргаас өгсөн чиг үүргийн талаарх мэдээллийг байгууллагын цахим системд, хэлтсийн дотоод цахим шуудангаар тогтмол мэдээлэл хийсэн байна. Түүнчлэн агентлагийн даргаас өгсөн үүргийн дагуу яамнаас ирүүлсэн мэдээлэл болон даргаас өгсөн үүргүүдийн талаарх бүртгэл хөтлөн хэрэгжилтийн талаар 5 удаа танилцуулан ажиллаж, албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах хүрээнд 6 албан хаагчийн ажлын байрны шилжилт хөдөлгөөн хийн ажиллуулсан байна. | 01-06 | 100 |
| 10 | Арга хэмжээ 5.3.Байгууллага, нэгжид хуваарилагдсан баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих | Хяналтын тоо | - | ERP цахим системээр ирүүлсэн, явсан бичгийн шийдвэрлэлтийн байдалд 1-ээс доошгүй удаа хяналт тавин удирдлага, албан хаагчдыг мэдээллээр хангах | ERP цахим системээр ирүүлсэн, явсан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж шийдвэрлэлтийн хугацаа хоцорсон болон, хугацаа дөхөж байгаа албан бичгийн талаар нийт албан хаагчдад дотоод цахим шуудангаар 2 удаа мэдээллэсэн. | 01-06 | 100 |
| 11 | Арга хэмжээ 5.4.Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллан зөвлөлийн шийдвэрийн баримтыг үүсгэж, хадгалах, шилжүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх | Шийдвэрийг баримтжуулсан ажлын гүйцэтгэлийн хувь | - | Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, хуралдааны шийдвэрийг баримтжуулах үйл ажиллагааг тухай бүрд нь 100 хувь хэрэгжүүлэх | Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд өөрчлөлт орсон тул тушаалын төслийг боловсруулан шинэчлэн батлуулсан. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дотоод ажлын цахим шуудproperties үүсгэж гишүүдэд 2 удаа мэдээлэл хийж, шаардлагатай журмуудын талаар мэдээлэл хийсэн. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж хэлэлцэж батлахад бэлэн болгосон. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт гарган бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллаж байна. | 01 | 100 |
| **НЭМЭЛТ АЖИЛ** | | | | | | | |
| 12 | Байгууллагаас олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, даргын гадаад улсад ажилласан мэдээллийн талаар БОУАӨЯ-ны БНБГ-т мэдээллийг тогтмол хүргүүлж ажиллах. | Дээд шатны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангасан байна | - | Мэдээллийг тогтмол хүргэж ажилласан байна. | 2025 оны 04 дүгээр сараас хойш зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний талаар мэдээллийг БОУАӨЯ-ны БНБХГ-ын ахлах шинжээчид цахим шуудангаар 8 удаа хүргүүлж ажилласан байна. Түүнчлэн агентлагийн даргын гадаад улсад ажилласан 5 удаагийн ажлын мэдээллийг хүргүүлэн ажиллав. | 04-06 | 100 |
| 13 | Байгууллагын ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавин дарга, албан хаагчдыг мэдээллээр хангаж ажиллах. | Албан хэрэг хөтлөх журмын хэрэгжилт хангагдана. | - | Албан бичгийг 100 хувь хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Байгууллагад ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн хугацааг сар бүр буюу 2 удаа шалгаж хугацаа дөхөж байгаа болон шийдвэрлээгүй судлагдаж байгаа албан бичгийн талаарх мэдээллийг байгууллагын viber дотоод цахим шуудангаар нийт албан хаагчдад мэдээлэл өгч ажиллав. | 04-06 | 100 |
| Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний дундаж хувь | | | | | | | **92.7** |

**ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин /эхний хагас жил/ | Хүрсэн түвшин /биелэлт/ | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1. Байгууллагаас болон Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна. | Мэдлэг чадвар дээшилсэн байна. | 2 | Зохион байгуулагдсан сургалтуудад тухай бүрд нь бүрэн хамрагдсан байна. | Авлигатай тэмцэх газартай авлигаас урьдчилан сэргийлэх болон ХАСХОМ-ийг бөглөх журмын талаар заасан сургалт болон тус газраас зохион байгуулсан "Сургагч багш бэлтгэх сургалт", Худалдан авах ажиллагааны сургалт, “Эрдэнэжамц сан” ТББ-тай хамтран нийт албан хаагчдад заасан сэтгэл зүй болон ёс зүйн талаарх сургалт, ISO 9001 стандартын сургалт, ЗГХЭГ-аас зохион байгуулсан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын талаарх сургалтад тус тус хамрагдсан. | 01-06 | 100 |
| 2 | Арга хэмжээ 2. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдах | Сертификат авсан байна. | - | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн багц сургалтад 2025.01.21-ээс 2025.05.20-ны өдрүүдэд суралцаж Сертификат авсан | 01-05 | 100 |
| Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж хувь | | | | | | | **100** |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЖАРГАЛ

2025 оны 06 сарын 10